



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**

Улсын Их Хурлын тамгын газрын 1 дүгээр байр,
Жанжин Д. Сүхбаатарын талбай 7, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/факс: (976-51) 26 45 36,
Цахим шуудан: info@prdi.mn,
Цахим хуудас: www.research.parliament.mn

2026.06.29 № 11001/0242
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЦЭНГҮҮН ТАНАА

Тус хүрээлэнд гүйцэтгэсэн “Төрийн шагналын
тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон
гарах зардлын тооцоо”-ны тайланг үүгээр хүргүүлж
байна.

Хавсралт: 21 хуудастай.

ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОДХҮҮ

1526030319



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ТӨРИЙН ШАГНАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Судалгааны төрөл: Зардлын тооцоо
Судалгааны код: ЗТ-26/108
Огноо: 2026-06-29

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн С.Цэнгүүн

Хянасан: ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр (Ph.D)
ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга Э.Дашзэгвэ

Судалгаа удирдсан: Судалгааны хэлтсийн зөвлөх Б.Оюун-Эрдэнэ

Судлаач: Б.Мөнхзориг

АГУУЛГЫН ТОВЬЁГ

Агуулгын товьёг	ii
Товчилсон үгийн жагсаалт	iii
Хүснэгтийн жагсаалт	iii
Удиртгал.....	1
НЭГ. ТӨРИЙН ШАГНАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО	3
1.1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо.....	3
1.2. Иргэний зардлын тооцоо.....	4
1.3 Төрийн байгууллагын зардлын тооцоо	6
1.3.1 Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа.....	6
1.3.2. Хүний нөөцийг тодорхойлох	8
1.3.3. Нэмэгдэх ажлын ачаалал	11
1.3.4. Гарах зардлыг урьдчилан тооцох.....	14
1.3.5. Нийт зардлыг тооцох.....	15
1.3.6. Хялбарчлах боломжийг шалгах.....	16
ХОЁР. ДҮГНЭЛТ	17
Ном зүй.....	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЗТБ	Төрийн захиргааны төв байгууллага
ТШТХТ	Төрийн шагналын тухай хуулийн төсөл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн үүрэг, гүйцэтгэх хугацаа, цалингийн зардал	3
Хүснэгт 2. Хуулийн этгээдэд үүсэх нийт зардал	4
Хүснэгт 3. Иргэний нийт ачаалал	5
Хүснэгт 4. Иргэнд үүсэх мөнгөн зардал	5
Хүснэгт 5. Төрийн байгууллагын үүрэг, стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа	6
Хүснэгт 6. Хүний нөөцийн хэрэгцээ.....	8
Хүснэгт 7. Нэг жилд шаардагдах хугацаа ба нэмэгдэх ажлын ачаалал.....	12
Хүснэгт 8. Дундаж материаллаг зардал	15
Хүснэгт 9. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал	15

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргана” гэж заасан байдаг. Энэ хүрээнд Төрийн шагналын тухай (анхдагч) хуулийн төслийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх чиг үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар төрийн шагналын төрөл, ангилал, эрэмбэ, олгох шалгуур болон жилд олгох шагналын тооны дээд хязгаарыг хуульчлан тогтоож, шагнал олгох үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах замаар хөдөлмөрийн зах зээлийн шударга үнэлэмж, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэхэд оршиж байна. Ингэснээр шагналын тогтолцоог орчин үеийн нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан шинэчилж, хувь хүний хөдөлмөрийн бодит үнэлэмж, бие даасан байдлыг хангахад чиглэж байна.

Тус хуулиар төрийн байгууллага, албан тушаалтнаас төрийн шагнал олгох, нэр дэвшүүлэх, тодорхойлох, шийдвэрлэх, бүртгэх, хадгалах, мэдээлэх болон тэдгээртэй холбогдон үүсэх иргэний эрх, үүргийн харилцааг нэгдсэн байдлаар зохицуулна. Мөн төрийн байгууллагуудын дотоод шагнал, түүнд тавигдах хязгаарлалт, хууль бусаар шагнал бий болгох, үйлдвэрлэхтэй холбоотой хориглох зүйл болон хүлээлгэх хариуцлагын тогтолцоог нарийвчлан зохицуулахаар тусгасан байна.

Өмнө нь Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, салбарын дүрэм зэрэг олон салангид дүрэм, журмаар зохицуулагдаж байсан харилцааг анх удаа бие даасан анхдагч хуулиар зохицуулахаар зорьж байна. Шагналыг бодит гавьяа зүтгэлд тулгуурлан олгохын тулд жилийн дээд хязгаарыг хатуу тогтоосон. Тухайлбал, Чингис хаан одонг 5 жилд 1 удаа, Салбарын хүндэт шагналын Гавьяат зүтгэлтэн тэмдгийг жилд 100 хүртэл, Алтан гадас одонг 500 хүртэл иргэнд олгохоор хязгаарласан байна. Түүнчлэн, шагналд нэр дэвшигчийн мэдээллийг шагнал олгохоос 30-аас доошгүй хоногийн өмнө албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулж, Төрийн шагналын мэдээллийн нэгдсэн санг үүсгэн авлига, ашиг сонирхлын зөрчлийг арилгана. Мөн төрийн байгууллагууд зөвхөн өөрийн ажилтныг урамшуулах шагналтай байх ба байгууллагад ажилладаггүй этгээдийг шагнах, нэрэмжит шагнал бий болгохыг хориглосон. Мөн төрийн шагналыг улс төрийн дэмжлэг авах, сонгуулийн үр дүнд нөлөөлөх хэрэгсэл болгон ашиглахыг таслан зогсоох зорилгоор УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулийн тухай хуулиудад нэмэлт оруулж, сонгуулийн үеэр шагнал олгох, урамшуулал өгөхийг хориглосон заалтуудыг хуулийн төсөлд тусган уялдуулсан байна.

Судалгааны зорилго: Төрийн шагналын тухай анхдагч хуулийн төсөл хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын хэмжээ, цаг хугацааны ачааллыг тооцож, төсөвт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны ажлын бүтэц: Хуулийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, зардлын тооцоог дараах агуулгын хүрээнд боловсруулав. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо;
2. Иргэнд үүсэх зардлын тооцоо;

3. Төрийн байгууллагын зардлын тооцоо.

Судалгааны арга зүй: Зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэв.

НЭГ. ТӨРИЙН ШАГНАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

1.1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо

Төрийн шагналын тухай хуулийн төсөл (цаашид ТШТХТ)-ийн 12.1, 12.5 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийн хувьд салбарын тэргүүлэх ажилтны материалыг судлах, баримт бичиг бүрдүүлэх, холбогдох төрийн байгууллага (Засаг даргын тамгын газар (ЗДТГ), төрийн захиргааы төв байгууллага (ТЗТБ), Ерөнхийлөгчийн Тамгын газар (ЕТГ))-д хүргүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Энэхүү үүргийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, маягт бөглөх, , дотоод хуралдаан (зөвлөлгөөн), мэдээлэл шилжүүлэх зэрэг стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд үүнд зарцуулах хугацаа, хувийн хэвшлийн дундаж цалингийн хэмжээ, тухайн үйл ажиллагаанд зарцуулах цалин хөлсний нийт зардлыг Хүснэгт 1-т харууллаа. Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацааг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-ын хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загвар”-т тулгуурлан тооцсон болно. Харин нэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах цалин хөлсний зардлыг тооцохдоо Үндэсний статистикийн хорооноос улирал тутамд гаргадаг ажиллагчдын сарын дундаж цалингийн мэдээллээс хувийн хэвшлийн 2025 оны 4 дүгээр улирлын мэдээнд үндэслэж, нэг минутад ногдох цалингийн хэмжээг тооцож, тухайн үйл ажиллагаанд ногдох цалин хөлсний зардлыг тооцсон болно.

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн үүрэг, гүйцэтгэх хугацаа, цалингийн зардал

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Дундаж цалин хөлс (Сараар)	Цалин хөлсний зардал
Хуулийн этгээд (ААНБ, ТББ)	ТШТХТ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 Төрийн шагналд Монгол Улсын иргэн өөрийгөө болон бусад иргэнийг, хуулийн этгээд нь иргэнийг нэр дэвшүүлэх эрхтэй. 12.5 Бүрдүүлбэрт хүсэлт, танилцуулга, амжилт бүтээлийг нотолсон баримт хавсаргах.	Ажилтны гавьяа зүтгэл, бүтээлийн жагсаалт, архивын баримт мэдээлэл цуглуулах	120	2,454,500	29,220
		Нэр дэвшигчийн анкет, танилцуулгыг бэлтгэх	30	2,454,500	7,305
		Байгууллагын хурлаар хэлэлцүүлэх	30	2,454,500	7,305
		Бэлэн болсон материалыг цахимаар (эсвэл биеэр) холбогдох яам, ЗДТГ, ЕТГ-т хүргүүлэх	10	2,454,500	2,435

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Аргачлалын 2.5, 2.6-д заасны дагуу тохиолдлын болон давтамжийн тоо (жилд 1 удаа)-г тодорхойлж, тэдгээрийн үржвэрээр тоон үзүүлэлтийг тооцсоныг Хүснэгт 2-т харууллаа.

Тохиолдлын тоог тооцохдоо хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан төрийн шагналаар нэг жилд шагнах тооны хязгаар (633)-т үндэслэн тооцов.

Ийнхүү хуулийн этгээдэд үүсэх нийт зардлыг тооцохдоо тоон үзүүлэлтийг Хүснэгт 1-т тооцсон тухайн үйл ажиллагаанд ногдох цалин хөлсний зардлаар үржүүлж тооцов (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Хуулийн этгээдэд үүсэх нийт зардал

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Цалин хөлсний зардал	Давтам-жийн тоо	Тохиолд-лын тоо	Тоон үзүүлэлт	Нийт зардал (төгрөгөөр)
ТШТХТ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 Төрийн шагналд Монгол Улсын иргэн өөрийгөө болон бусад иргэнийг, хуулийн этгээд нь иргэнийг нэр дэвшүүлэх эрхтэй. 12.5 Бүрдүүлбэрт хүсэлт, танилцуулга, амжилт бүтээлийг нотолсон баримт хавсаргах.	Ажилтны гавьяа зүтгэл, бүтээлийн жагсаалт, архивын баримт мэдээлэл цуглуулах	29,220	1	633	633	18,496,411
	Нэр дэвшигчийн анкет, танилцуулгыг бэлтгэх	7,305	1	633	633	4,624,103
	Байгууллагын хурлаар хэлэлцүүлэх	7,305	1	633	633	4,624,103
	Бэлэн болсон материалыг цахимаар (эсвэл биеэр) холбогдох яам, ЗДТГ, ЕТГ-т хүргүүлэх	2,435	1	633	633	1,541,368
НИЙТ						29,285,983.63

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Ийнхүү хуулийн төслийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдийн түвшинд 633 хүнийг төрийн шагналд нэр дэвшүүлэхэд шаардагдах цаг хугацааны ачаалалд ногдох зардал нь ойролцоогоор 29.3 сая төгрөг бөгөөд үүнээс нэр дэвшүүлж байгаа ажилтны баримт мэдээллийг бэлтгэх үйл ажиллагаанд ногдох зардал 63 хувийг эзэлж байна.

1.2. Иргэний зардлын тооцоо

Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт Төрийн шагналд Монгол Улсын иргэн өөрийгөө болон бусад иргэнийг нэр дэвшүүлэх эрхтэй, 10.1.2-т Төрийн шагналд нэр дэвшүүлэхдээ үнэн зөв баримт бичиг, мэдээлэл гаргаж өгөх үүрэгтэй гэж заасан. Энэ хүрээнд иргэний хувьд үүсэх ачааллыг Аргачлалын дагуу тооцсоныг Хүснэгт 3-т харууллаа. Тохиолдлын тоог хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан дээд хязгаараар буюу 633 хүн өөрийгөө болон бусад иргэнийг нэр дэвшүүлэхээр тооцсон болно. Харин үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацааг Аргачлалын хавсралтаар батлагдсан "Иргэний үүсэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн цаг хугацааг тооцох загвар"-т үндэслэн тооцлоо.

Хүснэгт 3. Иргэний нийт ачаалал

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Давтамжийн тоо	Тоон үзүүлэлт	Нийт ачаалал /мин/
ТШТХТ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 Төрийн шагналд Монгол Улсын иргэн өөрийгөө болон бусад иргэнийг, хуулийн этгээд нь иргэнийг нэр дэвшүүлэх эрхтэй. 10.1.2 Төрийн шагналд нэр дэвшүүлэхдээ үнэн зөв баримт бичиг, мэдээлэл гаргаж өгөх	Тухайн шатны ЗДТГ эсвэл мэргэжилтнээс цахимаар/ утсаар зааварчилгаа авах	10	633	1	633	6,330
	Өөрийн бүтээл, дипломын хуулбар, гавьяа зүтгэлийг гэрчлэх баримтыг цуглуулах	20	633	1	633	12,660
	Танилцуулга бичих, амжилтуудаа он цагийн дараалалд оруулах	5	633	1	633	3,165
	Мэдээллээ холбогдох газарт илгээх	2	633	1	633	1,266
НИЙТ						23,421

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Ийнхүү хуулийн төсөл хэрэгжсэнээр иргэний хувьд үүсэх нийт ачаалал нь жилд ойролцоогоор 23,421 минут байна.¹ Аргачлалын 3.6-д Шаардлагатай тохиолдолд зайлшгүй гарах нэмэлт зардал буюу үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс гарах мөнгөн зардлыг тооцож гаргаж болохоор заасан. Иргэнээс зайлшгүй гарах бодит мөнгөн зардалд нотариатын төлбөр, цээж зураг авхуулах зэрэг зардал орох (Аргачлалын 3.4.3) бөгөөд үүнийг 633 иргэний хувьд тооцсоныг Хүснэгт 4-т харууллаа. Нотариатын төлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 123 тоот тушаалаар баталсан "Нотариатын үйлчилгээний хөлс, зардал"-ын хэмжээгээр дунджлан тооцов.

Хүснэгт 4. Иргэнд үүсэх мөнгөн зардал

Зардлын нэр	Нэгж үнэ	Тохиолдлын тоо	Нийт зардал
Нотариатын үйлчилгээний хөлс	5,000	633	3,165,000
Цээж зураг	20,000	633	12,660,000
НИЙТ			15,825,000

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

¹ Тайлбар: Энэхүү тооцоолол нь хуулийн төслийн дагуу тогтоосон дээд хязгаараар авсан тооцоолол бөгөөд практик дээр байгууллагын зүгээс ажилтнаа шагналд нэр дэвшүүлэх тохиолдол харьцангуй олон байдаг тул иргэний хувьд энэ тооцооллоос бага ачаалал үүсэх болно.

Ийнхүү Төрийн шагналын тухай хуулийн төслийн дагуу иргэн өөрийгөө болон бусад иргэнийг төрийн шагналд нэр дэвшүүлэхэд гарах бодит мөнгөн зардалд ойролцоогоор 15,8 сая төгрөг зарцуулахаар байна.

1.3 Төрийн байгууллагын зардлын тооцоо

1.3.1 Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

Төрийн шагналын тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр аймаг, дүүргийн засаг даргын тамгын газар (ЗДТГ), төрийн захиргааны төв байгууллагууд (ТЗТБ), Ерөнхийлөгчийн Тамгын газар (ЕТГ)-ын чиг үүрэгт зарим нэмэлт үүргүүд үүсэж байна. Тэдгээрт хамаарах стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацааг Хүснэгт 5-т харууллаа. Стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах хугацааг Аргачлалын Хавсралт 1-ээр батлагдсан “Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загвар”-т үндэслэн тооцсон болно. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу УИХ-ын холбогдох Байнгын хороо Тамгын газартай хамтран хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах нийтлэг үүргийг тусгав.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын үүрэг, стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа (Standard Procedure)	Зарцуулах хугацаа/мин/
Улсын Их Хурал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	1,200
			300
			600
		Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	480
			480
Ерөнхийлөгчийн Тамгын газар	ТШТХТ-ийн 12.2.1. Төрийн дээд шагналд нэр дэвших хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт	Холбогдох яамд болон ЗДТГ-аас уламжлан ирүүлсэн нэр дэвшигчдийн бүрдүүлбэр, танилцуулга, бүтээлийн жагсаалт, гавьяа зүтгэлийн тодорхойлолт хуулийн шаардлага хангасан эсэхийг нэг бүрчлэн хянаж, судлах.	60
		Хуульд заасан жилийн дээд хязгаар (квот)-т багтаан сонгогдох боломжтой шалгарсан нэр дэвшигчдийг эрэмбэлэх, шагнал тус бүрээр үндэслэл бүхий танилцуулга, шагнуулах тухай санал боловсруулах.	60
		ЕТГ-ын даргын гарын үсгээр баталгаажсан зарлигийн төсөл, холбогдох материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.	10
		Ерөнхийлөгчийн зарлиг гарсны дараа зарлигийг албажуулан хэвлэх, Төрийн шагналын мэдээллийн санд	15

		шинээр шагнагдсан иргэний бүртгэлийг үүсгэх, архивын нэгж болгон хадгалах.	
Төрийн захиргааны төв байгууллага (яамд)	ТШТХТ-ийн 12.2.2. Салбарын хүндэт шагнал, энхийг сахиулах үйлсийн хүндэт шагналд нэр дэвших хүсэлтийг харьяалах салбарын төрийн захиргааны төв байгууллагад; 12.4.1.Энэ зүйлийн 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлон, өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг хавсарган тамга, гарын үсгээр баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүргүүлнэ; 14.4.2.Нэр дэвшигчийн бүрдүүлбэр шаардлага хангаагүй тохиолдолд энэ зүйлийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага 30 хоногийн дотор нэр дэвшигчид энэ тухай мэдэгдэнэ.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн салбарын шагналын материалыг хуулийн 6.2, 6.3-т заасан шалгуурт нийцэж буй эсэхийг судлах.	120
		Тухайн салбарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан нотлох баримтыг цуглуулах.	120
		Нэр дэвшигчийг өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг салбарын сангаас шүүж нягтлах	45
		Бүрдүүлбэр шаардлага хангаагүй бол 30 хоногийн дотор нэр дэвшигчид мэдэгдэж буцаах, засуулах.	60
		Салбарын хэмжээнд шаардлага хангасан нэр дэвшигчдийг тодорхойлж, албан ёсны санал боловсруулах.	120
		Тодорхойлсон материалыг лавлагааны хамт ЕТГ-т албан бичгээр шилжүүлэх.	10
		Ирүүлсэн болон уламжилсан материалын хуулбарыг яамны архивын нэгж болгон хадгалах.	15
Аймаг, дүүргийн ЗДТГ	ТШТХТ-ийн 12.2.3. Мал сүргийн эдийн засгийн үр өгөөжийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагнал, Иргэний хүндэт шагнал болон хүн амыг өсгөх бодлогын хүрээнд олгох шагналд нэр дэвших хүсэлтийг харьяаллын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт; 12.4.1.Энэ зүйлийн 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлон, өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг хавсарган тамга, гарын үсгээр баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүргүүлнэ; 14.4.2.Нэр дэвшигчийн бүрдүүлбэр шаардлага хангаагүй тохиолдолд энэ зүйлийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т	Малчин, иргэн болон эхчүүдийн материалыг хуулийн 6.4, 6.5, 6.6-д заасан шалгуурт (мал эмнэлэгт хамрагдсан байдал, татвар төлөлт гэх мэт) нийцэж буйг судлах	60
		Сум, дүүргээс ирүүлсэн малчдын болон эхчүүдийн баримт бичиг, холбогдох тодорхойлолтуудыг цуглуулах.	60
		Татвар төлөлт, бэлчээр ашиглалт, хүүхдийн тоо зэрэг өгөгдлийг улсын бүртгэл болон татварын системтэй тулган нягтлах	20
		Бүрдүүлбэр дутуу, шалгуур хангаагүй бол 30 хоногийн дотор иргэнд албан ёсоор мэдэгдэж буцаах	20

	заасан байгууллага 30 хоногийн дотор нэр дэвшигчид энэ тухай мэдэгдэнэ.; 13.2.2.Төрийн хүндэт шагнал, Хүн амын өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагнал, Мал сүргийн эдийн засгийн үр өгөөжийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч эсхүл түүний даалгавраар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга	Аймгийн хэмжээнд шалгуур хангасан нэр дэвшигчдийг квотод багтаан эрэмбэлж, санал бэлтгэх.	20
		Баталгаажсан материалыг ЕТГ-т хүргүүлэх.	10
		Орон нутагт шагнал гардуулсан тухай тэмдэглэл үйлдэж, хувийг архивлах.	15

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Төрийн шагналын тухай анхдагч хуулийн төсөл хэрэгжсэнээр холбогдох төрийн байгууллагуудын хувьд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн материалыг хуулийн шалгуурт нийцэж буй эсэхийг судлах, баталгаажуулахад хамгийн их хугацааг зарцуулахаар байна.

1.3.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа, 1 жилд гүйцэтгэх тоо /цаашид "давтамжийн тоо" гэх/ болон нэг жилд хэдэн байгууллага, иргэнд үйлчлэх тохиолдлын тоог нэг ажилтанд шаардагдах нийт ажлын цагийн хамт тооцож гаргана.

Нэг ажилтанд шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуулийн 84.2 дахь хэсэгт заасан нэг өдрийн ердийн ажлын цагт үндэслэж, нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнээр тооцов:

1 жил = ажлын 249 өдөр /Календарийн ажлын өдөр/

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хууль/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 249 ажлын өдөр буюу (249 x 8) 1992 цаг буюу (1992 x 60) **119,520 минут** ажиллана.

Тохиолдлын тоог тооцохдоо хуулийн төслийн дагуу төрийн шагналыг олгох хүний тооны хязгаараар тооцлоо (Хүснэгт 6). Ингэхдээ яамд болон ЗДТГ-т ногдох хүний тоог хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан хязгаарын дагуу ялгаатай тооцсон болно.

Хүснэгт 6. Хүний нөөцийн хэрэгцээ

Хариуцах байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо (нэг жилд гүйцэтгэх тоо)	Давтамжийн тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	1,200	1	1	1200
			300	1	1	300
			600	1	1	600
	Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах		480	1	1	480

	Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.		480	1	1	480
ЕТГ	ТШТХТ-ийн 12.2.1 Төрийн дээд шагналд нэр дэвших хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт:	Шат шатны Яамд болон ЗДТГ-аас уламжлан ирүүлсэн нэр дэвшигчдийн бүрдүүлбэр, танилцуулга, бүтээлийн жагсаалт, гавьяа зүтгэлийн тодорхойлолт хуулийн шаардлага хангасан эсэхийг нэг бүрчлэн хянаж, судлах.	60	633	1	37980
		Хуульд заасан жилийн дээд хязгаар (квот)-т багтаан сонгогдох боломжтой шалгарсан нэр дэвшигчдийг эрэмбэлэх, шагнал тус бүрээр үндэслэл бүхий танилцуулга, шагнуулах тухай санал боловсруулах.	60	633	1	37980
		ЕТГ-ын даргын гарын үсгээр баталгаажсан зарлигийн төсөл, холбогдох материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.	10	633	1	6330
		Ерөнхийлөгчийн зарлиг гарсны дараа зарлигийг албажуулан хэвлэх, Төрийн шагналын мэдээллийн санд шинээр шагнагдсан иргэний бүртгэлийг үүсгэх, архивын нэгж болгон хадгалах.	15	633	1	9495
ТЗТБ	ТШТХТ-ийн 12.2.2. Салбарын хүндэт шагнал, энхийг сахиулах үйлсийн хүндэт шагналд нэр дэвших хүсэлтийг харьяалах салбарын төрийн захиргааны төв байгууллагад; 12.4.1: Энэ зүйлийн 12.2.2,	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн салбарын шагналын материалыг хуулийн 6.2, 6.3-т заасан шалгуурт нийцэж буй эсэхийг судлах.	120	603	1	72360
		Тухайн салбарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан нотлох баримтыг цуглуулах.	120	603	1	72360

	12.2.3-т заасан байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлон, өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг хавсарган тамга, гарын үсгээр баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүргүүлнэ; 14.4.2 Нэр дэвшигчийн бүрдүүлбэр шаардлага хангаагүй тохиолдолд энэ зүйлийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага 30 хоногийн дотор нэр дэвшигчид энэ тухай мэдэгдэнэ.	Нэр дэвшигчийг өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг салбарын сангаас шүүж нягтлах	45	603	1	27135
		Бүрдүүлбэр шаардлага хангаагүй бол 30 хоногийн дотор нэр дэвшигчид мэдэгдэж буцаах, засуулах.	60	603	1	36180
		Салбарын хэмжээнд шаардлага хангасан нэр дэвшигчдийг тодорхойлж, албан ёсны санал боловсруулах.	120	603	1	72360
		Тодорхойлсон материалыг лавлагааны хамт ЕТГ-т албан бичгээр шилжүүлэх.	10	603	1	6030
		Ирүүлсэн болон уламжилсан материалын хуулбарыг яамны архивын нэгж болгон хадгалах.	15	603	1	9045
ЗДТГ	ТШТХТ-ийн 12.2.3. Мал сүргийн эдийн засгийн үр өгөөжийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагнал, Иргэний хүндэт шагнал болон хүн амыг өсгөх бодлогын хүрээнд олгох шагналд нэр дэвших хүсэлтийг харьяаллын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт; 12.4.1: Энэ зүйлийн 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлон, өмнө	Малчин, иргэн болон эхчүүдийн материалыг хуулийн 6.4, 6.5, 6.6-д заасан шалгуурт (мал эмнэлэгт хамрагдсан байдал, татвар төлөлт гэх мэт) нийцэж буйг судлах	60	27	1	1620
		Сум, дүүргээс ирүүлсэн малчдын болон эхчүүдийн баримт бичиг, холбогдох тодорхойлолтуудыг цуглуулах.	60	27	1	1620
		Татвар төлөлт, бэлчээр ашиглалт, хүүхдийн тоо зэрэг өгөгдлийг улсын бүртгэл болон татварын системтэй тулган нягтлах	20	27	1	540
		Бүрдүүлбэр дутуу, шалгуур хангаагүй бол 30 хоногийн дотор иргэнд албан ёсоор мэдэгдэж буцаах	20	27	1	540

	нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг хавсарган тамга, гарын үсгээр баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүргүүлнэ; 14.4.2	Аймгийн хэмжээнд шалгуур хангасан нэр дэвшигчдийг квотод багтаан эрэмбэлж, санал бэлтгэх.	20	27	1	540
	Нэр дэвшигчийн бүрдүүлбэр шаардлага хангаагүй тохиолдолд энэ зүйлийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага 30 хоногийн дотор нэр дэвшигчид энэ тухай мэдэгдэнэ.; 13.2.2: Төрийн хүндэт шагнал, Хүн амын өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагнал, Мал сүргийн эдийн засгийн үр өгөөжийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч эсхүл түүний даалгавраар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга	Баталгаажсан материалыг ЕТГ-т хүргүүлэх.	10	27	1	270
		Орон нутагт шагнал гардуулсан тухай тэмдэглэл үйлдэж, хувийг архивлах.	15	27	1	405
НИЙТ						395,850

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Төрийн шагналын тухай анхдагч хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллагад үүсэх чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нийтдээ **395,850** минутын хүний нөөцийн хэрэгцээ үүсэхээр байна.

1.3.3. Нэмэгдэх ажлын ачаалал

Төрийн байгууллагад нэмэгдэх ачааллын хэмжээг тооцохдоо Аргачлалын 4.4.7-д заасны дагуу тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдаж байгаа хүний нөөцийн хэрэгцээг хугацаа (мин)-гаар илэрхийлснийг жилд шаардагдах ажлын цагийн хэмжээнд хувааж тооцов (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Нэг жилд шаардагдах хугацаа ба нэмэгдэх ажлын ачаалал

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэх ажлын ачаалал
Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1.Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	1,200	119,520	0.01
		300	119,520	0.003
		600	119,520	0.01
	Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	480	119,520	0.004
		480	119,520	0.004
ТШТХТ-ийн 12.2.1.Төрийн дээд шагналд нэр дэвших хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт:	Шат шатны Яамд болон ЗДТГ-аас уламжлан ирүүлсэн нэр дэвшигчдийн бүрдүүлбэр, танилцуулга, бүтээлийн жагсаалт, гавьяа зүтгэлийн тодорхойлолт хуулийн шаардлага хангасан эсэхийг нэг бүрчлэн хянаж, судлах.	37980	119,520	0.318
	Хуульд заасан жилийн дээд хязгаар (квот)-т багтаан сонгогдох боломжтой шалгарсан нэр дэвшигчдийг эрэмбэлэх, шагнал тус бүрээр үндэслэл бүхий танилцуулга, шагнуулах тухай санал боловсруулах.	37980	119,520	0.318
	ЕТГ-ын даргын гарын үсгээр баталгаажсан зарлигийн төсөл, холбогдох материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.	6330	119,520	0.053
	Ерөнхийлөгчийн зарлиг гарсны дараа зарлигийг албажуулан хэвлэх, Төрийн шагналын мэдээллийн санд шинээр шагнагдсан иргэний бүртгэлийг үүсгэх, архивын нэгж болгон хадгалах.	9495	119,520	0.079
ТШТХТ-ийн 12.2.2.Салбарын хүндэт шагнал, энхийг сахиулах үйлсийн хүндэт шагналд нэр дэвших	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн салбарын шагналын материалыг хуулийн 6.2, 6.3-т заасан	72360	119,520	0.605

хүсэлтийг харьяалах салбарын төрийн захиргааны төв байгууллагад; 12.4.1.Энэ зүйлийн 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлон, өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг хавсарган тамга, гарын үсгээр баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүргүүлнэ; 14.4.2.Нэр дэвшигчийн бүрдүүлбэр шаардлага хангаагүй тохиолдолд энэ зүйлийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага 30 хоногийн дотор нэр дэвшигчид энэ тухай мэдэгдэнэ.	шалгуурт нийцэж буй эсэхийг судлах.			
	Тухайн салбарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан нотлох баримтыг цуглуулах.	72360	119,520	0.605
	Нэр дэвшигчийг өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг салбарын сангаас шүүж нягтлах	27135	119,520	0.227
	Бүрдүүлбэр шаардлага хангаагүй бол 30 хоногийн дотор нэр дэвшигчид мэдэгдэж буцаах, засуулах.	36180	119,520	0.303
	Салбарын хэмжээнд шаардлага хангасан нэр дэвшигчдийг тодорхойлж, албан ёсны санал боловсруулах.	72360	119,520	0.605
	Тодорхойлсон материалыг лавлагааны хамт ЕТГ-т албан бичгээр шилжүүлэх.	6030	119,520	0.050
	Ирүүлсэн болон уламжилсан материалын хуулбарыг яамны архивын нэгж болгон хадгалах.	9045	119,520	0.076
ТШТХТ-ийн 12.2.3.Мал сүргийн эдийн засгийн үр өгөөжийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагнал, Иргэний хүндэт шагнал болон хүн амыг өсгөх бодлогын хүрээнд олгох шагналд нэр дэвших хүсэлтийг харьяаллын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт; 12.4.1.Энэ зүйлийн 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлон, өмнө нь шагнагдаж байсан эсэх талаарх лавлагааг хавсарган тамга, гарын үсгээр баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүргүүлнэ;	Малчин, иргэн болон эхчүүдийн материалыг хуулийн 6.4, 6.5, 6.6-д заасан шалгуурт (мал эмнэлэгт хамрагдсан байдал, татвар төлөлт гэх мэт) нийцэж буйг судлах	1620	119,520	0.014
	Сум, дүүргээс ирүүлсэн малчдын болон эхчүүдийн баримт бичиг, холбогдох тодорхойлолтуудыг цуглуулах.	1620	119,520	0.014
	Татвар төлөлт, бэлчээр ашиглалт, хүүхдийн тоо зэрэг өгөгдлийг улсын бүртгэл болон татварын системтэй тулган нягтлах	540	119,520	0.005
	Бүрдүүлбэр дутуу, шалгуур хангаагүй бол 30 хоногийн дотор иргэнд албан ёсоор мэдэгдэж буцаах	540	119,520	0.005
	Аймгийн хэмжээнд шалгуур хангасан нэр дэвшигчдийг квотод багтаан эрэмбэлж, санал бэлтгэх.	540	119,520	0.005

14.4.2.Нэр дэвшигчийн бүрдүүлбэр шаардлага хангаагүй тохиолдолд энэ зүйлийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т заасан байгууллага 30 хоногийн дотор нэр дэвшигчид энэ тухай мэдэгдэнэ.;	Баталгаажсан материалыг ЕТГ-т хүргүүлэх.	270	119,520	0.002
13.2.2.Төрийн хүндэт шагнал, Хүн амын өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагнал, Мал сүргийн эдийн засгийн үр өгөөжийг дэмжих бодлогын хүрээнд олгох шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч эсхүл түүний даалгавраар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга	Орон нутагт шагнал гардуулсан тухай тэмдэглэл үйлдэж, хувийг архивлах.	405	119,520	0.003
НИИТ		395,850		3.31

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Төрийн шагналын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн салбарын шагналын материалыг хуулийн шалгуурт нийцэж буй эсэхийг судлах, шалгуур хангасан нэр дэвшигчдийг квотод багтаан эрэмбэлж, санал бэлтгэх зэрэг чиг үүргийг ЕТГ, холбогдох яамд, ЗДТГ-ын түвшинд хэрэгжүүлэхэд ойролцоогоор **395,850** мин зарцуулах шаардлагатай бөгөөд ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд нэмэгдэх ачааллыг ажилтны тоогоор илэрхийлбэл **3.31** болж байна.

1.3.4. Гарах зардлыг урьдчилан тооцох

Гарах зардлыг Аргачлалын дагуу урьдчилан тооцохын тулд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр тооцно. Хүний нөөцийн зардлыг тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох цалин, нэмэгдэл, тусламж, төрөөс хариуцдаг бусад бүх зардлыг нэгтгэн дунджаар тооцно. Хуулийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллагуудын цалин, нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын дундаж хэмжээ УИХ-ын Тамгын газар болон ЕТГ-ын албан хаагчийн албан тушаалд 5,752,002 төгрөг², ТЗТБ-ын төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалд 2,718,300³, нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан тушаалд 2,134,210⁴ төгрөг, дунджаар 3,531,143 төгрөг байна. Иймд, төрөөс нэмж гарах хүний нөөцийн зардлыг урьдчилан тооцвол дунджаар **11,688,083 (3,531,143*3.31)** төгрөг байна.

Аргачлалын 4.5.2-т зааснаар материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлууд буюу ажлын байрны түрээсийн төлбөр, эд хөрөнгийн элэгдэл хорогдол, цахилгаан дулаан, бичиг хэрэг, техник, тоног төхөөрөмж, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлууд хамаардаг. Иймд, нэгж одон, медаль, цол тэмдгийг хийлгэхэд зарцуулдаг дундаж зардлыг зарим төрийн захиргааны төв байгууллагуудаас ирүүлсэн 2024 оны зардлын мэдээнд үндэслэн (хэт өндөр тоог хасч) тооцсон бөгөөд нийт материаллаг

² Их Хурлын 2020 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

³ Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

⁴ Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

зардлыг жилд олгох хүний тоо буюу нийт тохиолдлын тоо (633)-нд үржүүлж тооцлоо (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Дундаж материаллаг зардал

Д/д	Яамд	2024 онд олгосон шагналын тоо	Зардал	Нэгж зардал
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	292	2,437,000,000	8,345,890
2	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	3,867	52,968,200	13,697
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	1,557	21,225,300	13,632
4	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	2,282	30,902,530	13,542
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	1,826	24,200,000	13,253
6	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	1,670	19,975,000	11,961
7	Батлан хамгаалах яам	2,658	26,668,500	10,033
8	Гадаад харилцааны яам	4	40,000	10,000
9	Эрчим хүчний яам	1,232	12,246,700	9,941
10	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	1,661	14,798,700	8,910
11	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	1,896	14,835,000	7,824
12	Боловсролын яам	7,378	56,200,000	7,617
13	Эрүүл мэндийн яам	4,400	29,877,620	6,790
14	Сангийн яам	3,013	18,317,000	6,079
НИЙТ		33,444	2,759,254,550	8,479,171
ДУНДАЖ		-	-	82,504
ДУНДАЖ (ХХААХҮЯ оруулаагүй)		-	-	10,252
Нийт материаллаг дундаж зардал (10,252*633)		-	-	6,489,722

Эх сурвалж: Яамд, судлаачийн боловсруулснаар

Төрийн шагналын тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр нийт материаллаг зардалд жилд дунджаар 6.5 сая төгрөг зарцуулахаар байна.

1.3.5. Нийт зардлыг тооцох

Нийт зардлыг Аргачлалын 4.6-д заасны дагуу өмнө тооцож гаргасан хүний нөөцийн зардлыг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж, материаллаг болон бусад зардлыг нэмж тооцов (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Нэг ажилтанд ногдох хүний нөөцийн дундаж зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)	Бусад (төгрөгөөр)	Нийт
Төрийн байгууллага	3.31	3,531,143	6,489,722	-	18,177,805
НИЙТ					18,177,805

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Уг хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр хуулийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллагууд, түүний албан хаагчдын хүний нөөцийн цалингийн зардалд нийт 11,688,083 (3,531,143*3.31) төгрөг, материаллаг зардалд 6,489,722 төгрөг, нийтдээ ойролцоогоор **18,177,805 (~арван найман сая нэг зуун далан долоон мянга)** төгрөгийн зардал үүсэхээр байна.

Ийнхүү, Төрийн шагналын тухай тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын Нэгдсэн төсвийн зарлагад ойролцоогоор 18.2 сая төгрөг нэмж шаардагдахаар байна.

1.3.6. Хялбарчлах боломжийг шалгах

Аргачлалын 2.7 болон 4.7-д заасны дагуу хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэж буй захиргааны ачааллыг бууруулах, зардлыг хялбарчлах боломжийг судалж үзэхэд дараах хувилбаруудыг авч үзэх боломжтой байна:

1.Цахимжилтын нэгдсэн шийдэл нэвтрүүлэх буюу иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй баримт бичгийг цахимжуулж, "E-Mongolia" системтэй бүрэн уялдуулах боломжтой. Ингэснээр иргэдээс зайлшгүй гарч буй нотариатын үйлчилгээний хөлс болон цээж зургийн зардлыг бүрмөсөн хасаж, иргэний санхүүгийн ачааллыг бууруулах боломжтой. Мөн иргэний баримт бичиг цуглуулах, илгээх цаг хугацааны ачааллыг нэг нэр дэвшигч тутамд хэмнэх боломжтой.

2.Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем ашиглах буюу хуулийн этгээдээс шаарддаг ажилтны боловсрол, мэргэжил, ажилласан жил зэрэг мэдээллийг ХУР системээс автоматаар татдаг болгосноор хуулийн этгээдийн мэдээлэл цуглуулах, анкет бэлтгэх хугацааг бууруулна. Энэ нь 633 тохиолдлын хэмжээнд хуулийн этгээдийн цалингийн урсгал зардлыг хэмнэх боломжтой юм.

3.Төрийн байгууллагуудын давхардсан шалгалтыг арилгах буюу хуулийн төслийн 14 дүгээр зүйлд заасан "Төрийн шагналын мэдээллийн сан"-г яамд болон ЗДТГ-ууд шууд ашиглаж, өмнө нь шагнагдаж байсан эсэх лавлагааг автоматаар шүүдэг болгох нь төрийн албан хаагчдын хяналтын хугацааг хувь хүн тутамд богиносгоно. Үүний үр дүнд төрийн байгууллагуудад шинээр нэмэгдэх ажлын ачааллыг бууруулж, хүний нөөцийн урсгал зардлаас хэмнэх боломж бүрдэнэ.

ХОЁР. ДҮГНЭЛТ

Төрийн шагналын тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх зардал, ажлын ачааллыг Аргачлалын дагуу тооцоход дараах үр дүн гарлаа:

Хуулийн төслийн 12.1, 12.5 дахь хэсэгт заасны дагуу шинээр үүсэж буй чиг үүргүүдийг хэрэгжүүлэх, баримт бичиг бүрдүүлэх үйл ажиллагаанд хуулийн этгээдийн (ААНБ, ТББ) хувьд жилд ойролцоогоор нийт 29,285,984 төгрөгийн захиргааны зардал бий болно. Үүнээс нэр дэвшигчийн гавьяа зүтгэл, архивын баримт мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ногдох цалингийн зардал хамгийн их буюу 63.2 хувийг (18,496,411 төгрөг) эзэлж байна.

Хуулийн төсөлд зааснаар иргэн өөрийгөө болон бусдыг нэр дэвшүүлэх, үнэн зөв баримт бичиг гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд 633 тохиолдлын хэмжээнд иргэдэд жилд нийт 23,421 минутын цаг хугацааны ачаалал үүснэ. Мөн баримт бичгийг нотариатаар батлуулах, цээж зураг авхуулах зэрэг зайлшгүй гарах бодит мөнгөн зардалд иргэдийн зүгээс нийт 15,825,000 төгрөгийн санхүүгийн ачаалал үүснэ.

Хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр ЕТГ, холбогдох салбарын яамд болон нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд хуулийн этгээд болон иргэдээс ирсэн материалыг хянах, лавлагаа хавсаргах, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд жилд нийт 395,850 минутын хүний нөөцийн хэрэгцээ үүсэж байна. Энэхүү нэмэгдэж буй ажлын ачааллыг бүтэн орон тоонд шилжүүлбэл улсын хэмжээнд 3.31 ажилтны нэмэлт ачаалал үүснэ. Санхүүгийн дүнгээр төрийн байгууллагуудын хүний нөөцийн цалинд жилд 11,688,083 төгрөг, одон медалийн үйлдвэрлэлийн материаллаг зардалд 6,489,722 төгрөг, нийтдээ 18,177,805 төгрөг шаардагдахаар байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад төрийн мэдээлэл солилцооны системд суурилсан цахимжуулалтын шийдлүүдийг журамд тусган нэвтрүүлснээр иргэний бодит зардлыг хэмнэж, төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн захиргааны ажлын цаг, ачааллыг бууруулах бүрэн боломжтой байна.

НОМ ЗҮЙ

- Хууль тогтоомжийн тухай хууль (2015);
- Хөдөлмөрийн тухай хууль (2021);
- Улсын Их Хурлын 2020 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт;
- Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралтууд;
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”;
- Зарим яам, агентлаг, ЗДТГ-аас ирүүлсэн мэдээллийг захиалагч УИХ-ын гишүүний ажлын албанаас 2026 оны 5 дугаар сарын 27-нд цахимаар уламжлан ирүүлсэн төрийн шагналын тоон мэдээлэл